



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023.04.18 № 895  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хандивын тайлангийн дүгнэлт  
хүргүүлэх тухай**

**Хандивын тайлангийн дүгнэлт**

Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус нөхөн сонгуульд оролцох Иргэдийн оролцооны нэгдэл намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус нөхөн сонгуульд оролцох нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу ээлжит бус нөхөн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

## Дүгнэлтийн үндэслэл

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Сүхбаатар дүүргийн Иргэдийн оролцооны нэгдэл намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

## Дүгнэлт

Сүхбаатар дүүргийн Иргэдийн оролцооны нэгдэл нам ээлжит бус нөхөн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны хандивын тайланд тусгасан нийт 3,524,000.00 /гурван сая таван зуун хорин дөрвөн мянган/ төгрөгийн хандивыг Улс төрийн намын тухай хуулиар тавьсан шаардлагын дагуу хүлээн авсан байна.

Сүхбаатар дүүргийн Иргэдийн оролцооны нэгдэл намаас ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хувийг: Нийслэл, Сүхбаатар дүүргийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2022.04.18 № 896

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Мөрийн хөтөлбөрт хийсэн аудитын  
дүгнэлт хүргүүлэх тухай

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын ээлжит бус нөхөн сонгуульд оролцох Иргэдийн оролцооны нэгдэл намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус нөхөн сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, нийслэлийн 2022-2023 оны төсвийн төсөөлөл, "Алсын хараа 2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Иргэдийн оролцооны нэгдэл нам Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн



сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сүхбаатар дүүргийн Иргэдийн оролцооны нэгдэл намын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг Нийслэл, Сүхбаатар дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт.....<sup>2</sup>..... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



## ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ

www.cup.mn

### 2023 ОНЫ СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМААС ДЭВШҮҮЛСЭН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

#### Нэг. Орон нутгийн нийгэм эдийн засгийн ерөнхий асуудлаар


- Орон нутагт бизнес эрхлэхэд таатай орчин бүрдэж чадсан эсэхийг иргэдийн нээлттэй сонсголоор хэлэлцүүлнэ.
- Орон нутгийн иргэд бүс нутгийн эдийн засаг, мэргэжлийн холбоодыг хэрхэн байгуулж ажиллах талаар иргэдээс санал авч хэлэлцүүлэг өрнүүлнэ, бизнесийн орчныг ойлгомжтой нээлттэй байлгах, олон улсын жишигт нийцсэн орон нутгийн холбоодтойгоор ажиллах соёлыг дэлгэрүүлнэ.
- Хог хаягдлын менежментийг сайжруулна.

#### Хоёр. Иргэдийн мэдэх эрхийн талаар

- Дүүрэгт эрх барьж буй нам, засаг захиргааны үйл ажиллагаанд хяналт тавьж олон нийтэд нээлттэй мэдээлж иргэдийн мэдэх эрхийг хангахад үйлчилж ажиллана.
- Долоо хоног бүр “Сөрөг хүчний төлөөлөл мэдээлж байна” сэдвээр хэвлэлийн бага хурал хийж, сөрөг хүчний хяналтыг хэрэгжүүлнэ.
- Дүүрэгт төсвийн задаргааг олон нийтэд нээлттэй тайлбарлана.
- Дүүргийн худалдан авах гэрээнүүдийг ил тод байлгахыг шаардаж ажиллана.
- Авилгын эсрэг хуулийн дагуу олон нийтийн хяналтад байх ёстой дүүргийн албан тушаалтны нэрсийн жагсаалтыг ил байлгана.
- Бүх хэвлэлүүдэд хаалтын гэрээгүй ажиллахыг сануулсан уриалга хүргүүлнэ. Хаалтын гэрээ бол авилгачдад үйлчилж буй хэрэг бөгөөд иргэдийн мэдэх эрхийг боогдуулсан үйл болохыг уйгагүй сануулна. Үр дүнд нь сонгодог утгаараа иргэддээ үйлчилж чаддаг чөлөөт хэвлэлтэй дүүрэг болно.

#### Гурав. Төсвийн асуудлаар

- Хямд өртгөөр, иргэдийн оролцоотойгоор хийж болох аливаа ажлыг хэт их мөнгөөр цөөхөн хүний гарт баялаг төвлөрүүлэх замаар хийлгэхгүй байхад анхаарна.
- Монголын нөхцөлд дор хаяж 24 сарын турш амжилттай ажиллаагүй бол аливаа шинэ, эрсдэлтэй технологид төсвийн хөрөнгө оруулалтын мөнгийг зарцуулахгүй гэсэн байр суурь баримтална.
- Орон нутгийн иргэдээс авч болох худалдан авалтыг дэмжинэ.
- Иргэдээс санал авч дэмжигдсэн хөрөнгө оруулалтад эхний ээлжийн хуваарилалт хийх бодлого баримтална.
- Нийтийг гамшгаас хамгаалах зориулалттай аливаа байгууламжийг байгуулах, сэргээх, эвдэж өөрчлөхгүй байхад анхаарна.
- Ашиглалтын зардал өндөртэй байгууламжинд төсвийн хөрөнгө оруулалтыг хийлгэхгүй байх, эсвэл багасгах бодлого баримтална.



## Дөрөв. Амьдрах орчныг сайжруулах асуудлаар

- Дүүрэгтээ ногоон стандартын барилга байгууламжийг нэмэгдүүлэх, ашиглалтын зардал багатай ухаалаг хөрөнгө оруулалт оруулж ирэхийг дэмжинэ.
- Хөрсний бохирдол, элэгдлээс хамгаалах энгийн хямд аргыг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулна.
- Органик хаягдлыг зөв менежментийг дүүрэгт дэлгэрүүлэх соён гэгээрүүлэх ажилд дүүргийн зүгээс хөрөнгө оруулах ажлыг зохион байгуулна.

